

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/215/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМАН ДАХЬ СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа	17
4.4 Зөвлөмж.....	18

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НХМ	Нэг хэвийн маягт
ОБГ	Онцгой байдлын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

11100 Буудал, Төв аймаг,
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuvzaudit.gov.mn

2022.02.25 № 01/93
Танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020322

D 2022/2022 он/ALBAN BICHIG

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,464,650.00	29,229,500.80
33	АВЛАГА	477,400.00	20,232,000.00
335	Бусад авлага	477,400.00	20,232,000.00
3351	Байгууллагаас авах авлага	477,400.00	20,232,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,987,250.00	8,997,500.80
351	Түүхий эд материал	00.00	2,380,950.80
35110	Тусгай зориулалттай материал	00.00	2,380,950.80
354	Хангамжийн материал	5,987,250.00	6,616,550.00
35410	Бичиг хэргийн материал	55,000.00	55,000.00
35420	Аж ахуйн материал	1,904,250.00	1,904,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	517,000.00	517,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,511,000.00	4,140,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,308,999.97	30,818,833.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,308,999.97	30,818,833.28
392	Биет хөрөнгө	1,308,999.97	30,818,833.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	30,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,287,500.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,540,000.00	1,540,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-231,000.03	-333,666.71
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,773,649.97	60,048,334.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,773,649.97	60,048,334.08
51	Засгийн газрын хувь оролцоо	4,863,919.00	4,863,919.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,909,730.97	55,184,415.08
51210	Өмнөх үеийн үр дүн	00.00	2,909,730.97
51220	Тайланг үеийн үр дүн	2,909,730.97	52,274,684.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,773,649.97	60,048,334.08

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	102,759,900.00	112,172,450.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	33,280,950.80
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	33,280,950.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	33,280,950.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	33,280,950.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	102,759,900.00	78,891,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,460,500.00	23,282,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,460,500.00	20,232,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,574,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	476,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,299,400.00	55,608,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	40,299,400.00	55,608,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	99,850,169.03	59,897,766.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,850,169.03	59,897,766.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,889,684.03	59,897,766.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,525,478.37	44,718,800.00
210101	Үндсэн цалин	51,525,478.37	44,718,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,489,639.93	5,589,900.00
210201	Тэтгэврийн даатгал	9,761,038.93	3,801,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	85,800.00	447,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	157,901.00	357,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	17,100.00	89,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	467,800.00	894,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,008,513.70	3,317,502.00
210401	Бичиг хэрэг	328,300.00	290,400.00
210402	Тээвэр, шатахуун	6,567,000.90	2,470,802.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	477,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	113,212.80	78,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,838,962.00	00.00
210604	Урсгал засвар	1,838,962.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	1,800,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	1,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,068,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,960,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,459,090.03	4,471,564.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,228,090.00	3,081,398.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	231,000.03	1,390,166.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,960,485.00	00.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,960,485.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,960,485.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,960,485.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,909,730.97	52,274,684.11
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,909,730.97	52,274,684.11

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл ₮
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	102,759,900.00	78,891,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	102,759,900.00	78,891,500.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00.00	476,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,460,500.00	22,806,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,232,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,574,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,299,400.00	55,608,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,299,400.00	55,608,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	101,219,899.00	78,891,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,219,899.00	78,891,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,219,899.00	58,659,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшыл	58,133,721.00	44,718,800.00
210101	Үндсэн цалин	58,133,721.00	44,718,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,266,765.30	5,589,900.00
210201	Тэтгэврийн даатгал	5,895,565.30	3,801,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	342,800.00	447,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	274,200.00	357,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	68,600.00	89,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	685,600.00	894,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,898,912.70	3,578,600.00
210401	Бичиг хэрэг	383,300.00	326,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,674,999.90	3,074,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	363,212.80	178,600.00
2105	Нормативт зардал	00.00	550,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	550,000.00
2107	Томиллолт, зочны зардал	500,000.00	1,800,000.00
210702	Дотоод албан томиллолт	500,000.00	1,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,960,000.00	145,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,460,500.00	2,276,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,460,500.00	2,276,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,960,485.00	20,232,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,960,485.00	20,232,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,960,485.00	20,232,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,540,001.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,540,001.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,540,000.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,863,919.00	00.00	00.00	00.00	4,863,919.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,909,730.97	00.00	2,909,730.97
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,863,919.00	00.00	2,909,730.97	00.00	7,773,649.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,863,919.00	00.00	2,909,730.97	00.00	7,773,649.97
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,863,919.00	00.00	2,909,730.97	00.00	7,773,649.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,863,919.00	00.00	2,909,730.97	00.00	7,773,649.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	52,274,684.11	00.00	52,274,684.11
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,863,919.00	00.00	55,184,415.08	00.00	60,048,334.08

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлэмжлэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,460,500.00	3,050,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,460,500.00	3,050,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,460,500.00	3,050,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,854,922.00	00.00
210101	Үндсэн цалин	23,854,922.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шямтгал	2,981,865.30	00.00
210201	Тэтгэврийн даатгал	2,981,865.30	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,163,212.70	774,000.00
210401	Бичиг хэрэг	200,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	5,299,999.90	774,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	00.00
210406	Бага үнэтэй, гүргэн эзгдэх, ахуйн эд зүйлс	363,212.80	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	00.00
2107	Томилго, зочны зардал	500,000.00	1,800,000.00
210702	Дотоод албан томилго	500,000.00	1,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,500,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,460,500.00	476,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,460,500.00	476,800.00
213	УРСГАЛШИТЖҮҮЛЭГ	0.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,460,500.00	3,050,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,460,500.00	3,050,800.00
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувааригдсан хөрөнгө	62,460,500.00	2,574,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	476,800.00

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,457,200.00	40,299,399.00	55,608,700.00	55,608,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,457,200.00	40,299,399.00	55,608,700.00	55,608,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,457,200.00	40,299,399.00	55,608,700.00	55,608,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,278,800.00	34,278,799.00	44,718,800.00	44,718,800.00
210101	Үндсэн цалин	34,278,800.00	34,278,799.00	44,718,800.00	44,718,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,284,900.00	4,284,900.00	5,589,900.00	5,589,900.00
210201	Тэтгэврийн даатгал	2,913,700.00	2,913,700.00	3,801,100.00	3,801,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	342,800.00	342,800.00	447,200.00	447,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	274,200.00	274,200.00	357,800.00	357,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	68,600.00	68,600.00	89,400.00	89,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	685,600.00	685,600.00	894,400.00	894,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,893,500.00	1,735,700.00	2,804,600.00	2,804,600.00
210401	Бичиг хэрэг	200,000.00	183,300.00	326,000.00	326,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,375,000.00	2,300,000.00	2,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	193,500.00	177,400.00	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	178,600.00	178,600.00
2105	Нормативт зардал	-	-	550,000.00	550,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	550,000.00	550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	145,400.00	145,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	95,400.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	50,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	1,800,000.00	1,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	1,800,000.00	1,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,457,200.00	40,299,399.00	55,608,700.00	55,608,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,457,200.00	40,299,399.00	55,608,700.00	55,608,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	40,457,200.00	40,299,399.00	55,608,700.00	55,608,700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	7	7	7
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2	2	2
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	4
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан

шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн анги нь “Монгол орны ойн санг хамгаалах нөхөн сэргээх зохистой ашиглах үржүүлэхэд хүний техник технологийн шинэ санаа санаачилгыг нэвтрүүлэн дэлхийн уур амьсгалын өөрчлөлт цөлжилттэй тэмцэхэд хувь нэмрээ оруулсан үнэ цэнэтэй байгууллага байхад оршино” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон, Төв аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэхээр ажиллахдаа Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн анги нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд
- Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд

гэсэн 3 чиглэлээр 25 арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн анги нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар буюу 1,497.8 мянган төгрөгөөр тогтоож, ерөнхий материаллаг байдал тооцох хувийг 75 хувиар буюу 1,123.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлаас 1.5 хувиар буюу 898.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 673.8 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 449.5 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн анги нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Газрын тухай газрын төлбөрийн хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “ аcolous ” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

Орлого:

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн анги нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 55,608.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 33,280.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн хуваарилагдаагүй зардлаас 20,232.0 мянган төгрөг, ногоон хэрэм төслөөс 2,574.0 мянган төгрөг, бусад орлого 476.8 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлого 112,172.5 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 55,608.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн хуваарилагдаагүй зардлаас 20,232.0 мянган төгрөг, ногоон хэрэм төслөөс 2,574.0 мянган төгрөг, бусад орлого 476.8 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 78,891.5 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/728 захирамжаар Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас Ногоон хэрэм төслийн хүрээнд бий болсон 500 га ойн зурвас, 20 га мод үржүүлгийн газрыг аймагт хүлээн авч, Лүн ойн ангид нэгтгэсэнтэй холбогдуулан, мод үржүүлгийн үйлчилгээний ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 20,232.0 мянган төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлснийг зарцуулалгүй, санхүүжилтийн авлагаар бүртгэж 20,232.0 мянган төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Зардал:

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн анги нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар 59,897.8 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 78,745.9 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141413001 тоот дансанд 55,899.8 мянган төгрөгийн орлого, 55,899.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100141413401 тоот дансанд 23,282.8 мянган төгрөгийн орлого, 23,282.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,540.0 мянган төгрөг, тайлант онд БОАЖЯ-с 2019 онд ирсэн 30,900.0 мянган төгрөгийн үнэтэй УАЗ фургон маркийн автомашиныг үнэ төлбөргүй хүлээж авсан байна.

Тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1,390.2 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 5,987.3 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 4,807.9 мянган төгрөг, хандиваар 2,380.9 мянган төгрөг, нийт 70,188.9

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 4,178.6 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 8,997.5 мянган төгрөг байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант жилийн авлагын данс эхний үлдэгдэл 477.4 мянган төгрөг, авлага нэмэгдсэн 20,232.0 мянган төгрөг, хасагдсан 477.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 20,232.0 мянган төгрөг байна.

Өглөгийн дансны эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 58,659.5 мянган төгрөг, хасагдсан 58,659.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 2 байгууллагатай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Авлага данс 20,232.0 мянган төгрөг, бараа материал 8,997.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 30,818.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	477.4	20,232.0	19,754.6
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	5,987.2	8,997.5	3,010.3
Үндсэн хөрөнгө	1,309.0	30,818.8	29,509.8
Нийт хөрөнгө	7,773.6	60,048.3	52,274.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,773.6	60,048.3	52,274.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,773.6	60,048.3	52,274.7

Ногоон хэрэм төслийн хүрээнд бий болсон 500 га ойн зурвас, 20 га мод үржүүлгийн газрыг аймагт хүлээн авч, Лүн ойн ангид нэгтгэсэнтэй холбогдуулан, мод үржүүлгийн үйлчилгээний ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 20,232.0 мянган төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлснийг зарцуулалгүй татан төвлөрүүлснийг санхүүжилтийн авлагаар бүртгэж 20,232.0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,997.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,010.3 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалд хандиваар 2,380.9 мянган төгрөгийн үүргэвчтэй гал унтраагч, үлээгч аппарат, 600

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

литрийн усны резинэн сав хүлээж авсан нь жилийн эцсийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 30,818.8 мянган төгрөг болж 29,509.8 мянган төгрөгөөр өсөхөд БОАЖЯ-с 2019 онд ирсэн 30,900.0 мянган төгрөгийн үнэтэй УАЗ фургон маркийн автомашиныг үнэ төлбөргүй хүлээж авсан.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 60,048.3 мянган төгрөг болж, 52,274.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 160,735.2 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөн, нийт урсгал зардалд 160,735.2 мянган төгрөг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 105,126.5 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 55,608.7 мянган төгрөг, урсгал зардлыг 55,608.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 55,608.7 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн авч, 55,608.7 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн зарцуулсан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас Ногоон хэрэм төслийн хүрээнд бий болсон 500 га ойн зурвас, 20 га мод үржүүлгийн газрыг аймагт хүлээн авч, Лүн суман дахь ойн ангид нэгтгэсэн байна.

Ойг нөхөн сэргээх, байгалийн сэргээх, ой модны ургалтад туслах ажлыг нэмэгдүүлж, ойн хортон шавж, модны өвчний тархалтын судалгаа, тэмцлийн ажлыг зохион байгуулж байна.

Ойн нөхөрлөлүүдэд менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ойн нөхөрлөлийн эрх, үүрэг, ойн менежментийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга замын талаар сургалт явуулж, боловсруулсан менежментийн төлөвлөгөөтэй танилцаж, мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар хэмнэлтийг тооцоолж, хэрэгжилтийг хянахад зайлшгүй биш зардал санхүүжигдээгүй бөгөөд, "Тэрбум мод тарих" ажлын бэлтгэл хангуулахад шаардлагатай зардлуудыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/728 захирамжаар мод үржүүлгийн үйлчилгээний ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 20,232.0 мянган төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэх асуудал шийдвэрлэгдэж, 2021 оны 12 дугаар сарын 22 нд дансанд орж ирсэн боловч, төрийн сангийн гүйлгээ хаагдсан тул санхүүжилтийн авлагаар бүртгэж 20,232.0 мянган төгрөг татан төвлөрүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 130 мэдээлэл байршуулж, 19 мэдээлэл хугацаа хоцроож 93.6 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн байна. Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний 22 тоот албан бичгээр төрийн аудитын газарт хэрэгжилтийг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын ойн ангийн түлш шатах тослох материалын зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж, байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,458.8 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 20,232.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 476.8 мянган төгрөгийн 1 зөрчилд акт тогтоож, 750.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/728 захирамжаар Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас Ногоон хэрэм төслийн хүрээнд бий болсон 500 га ойн зурвас, 20 га мод үржүүлгийн газрыг аймагт хүлээн авч, Лүн ойн ангид нэгтгэсэнтэй холбогдуулан, мод үржүүлгийн үйлчилгээний ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 20,232.0 мянган төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлсэн орлогыг зарцуулалгүй, татан төвлөрүүлснийг орлого зарлагаар бүртгээгүй алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Өмнөх оны зарцуулагдаагүй 476.8 мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлэлгүй өөр байгууллагад шилжүүлээд, 2021 онд үйл ажиллагааны орлогоор буцааж аваад зарцуулсан, албан ёсны анхан шатны баримтаар баталгаажуулаагүй зөрчилтэй санхүүгийн ажил гүйлгээ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэж заасныг хэрэгжүүлээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “ Үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Арвилан хэмнэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Монгол, Солонгосын Ногоон хэрэм төслөөс санхүүжүүлсэн Өмнөговь аймгийн сум дундын ойн ангийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлахаар явахдаа өөр байгууллагын 5 хүнд 750.0 мянган төгрөгийн албан томилолтын нөхөх төлбөр олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 ны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.9-д “Байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтээр албан томилолтоор ажиллах тохиолдолд харилцан тохиролцсоны үндсэн дээр албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж хариуцаж болно.” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, зайлшгүй ажлын шаардлагаар хамтран ажилласан тохиолдолд албан томилолтын нөхөх төлбөрийг үндсэн байгууллагатай харилцан тохиролцож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Лүн суман дахь сум дундын ойн анги	3	21,458.8	1	20,232.0	1	476.8	0	0.0	1	750.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70272287
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn